



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 520

Улаанбаатар хот

Төрийн өмчийн төлөөлөгчийг томилж,
удирдамж батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 2.9¹ дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний төрийн өмчит хувьцаат компаниудын Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд төрийн өмчийг төлөөлөн оролцох төлөөлөгчөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, мэргэжилтэн Ц.Шинэхүү нарыг томилсугай.


2. Эрчим хүчний төрийн өмчит хувьцаат компаниудын Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд өгөх саналын удирдамжийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

3. Эрчим хүчний төрийн өмчит хувьцаат компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр томилогдох гишүүдийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

4. Эрчим хүчний төрийн өмчит хувьцаат компаниудын Хувьцаа эзэмшигчдийн хуралд удирдамжийг баримтлан оролцох, хуралд оролцсон тайланг танилцуулахыг төрийн өмчийн төлөөлөгч Ц.Баяр-Эрдэнэ, Ц.Шинэхүү нарт даалгасугай.

ДАРГА 
Ц.НЯМ-ОСОР
ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Г.Гаваа
Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн
520 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ТӨРИЙН
ӨМЧИЙГ ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦОХ ТӨЛӨӨЛӨГЧИЙН
БАРИМТЛАХ УДИРДАМЖ

Төрийн өмчийн төлөөлөгч нь эрчим хүчний хувьцаат компаниудын Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар шийдвэр гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам” болон энэхүү удирдамжийг баримтална:

1. Эрчим хүчний төрийн өмчит хувьцаат компаниудын Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хурлын даргыг сонгоход санал өгч оролцох;
2. Эрчим хүчний төрийн өмчит хувьцаат компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүдийг томилох асуудлыг хэлэлцэж Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 335 дугаар тогтоолоор “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам”-д орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу ... Эрчим хүчний төрийн өмчит компаниудын хувьцааны 30 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар эзэмшиж, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөх этгээдийг томилж чөлөөлнө” гэж заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдыг томилоход холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхэд санал өгч оролцох;

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 5-дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛД ТӨРИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГИШҮҮНЭЭР
ТОМИЛОХ ГИШҮҮДИЙН ЖАГСААЛТ

№	Хуулийн этгээдийн нэрс	ТУЗ-ийн гишүүд
1	Дулааны цахилгаан станц-2 ХК	1.Т.Лхагвасүрэн-ТӨБЗГ-ын мэргэжилтэн 2. Ч.Батчимэг- ТӨБЗГ-ын мэргэжилтэн
2	Дулааны цахилгаан станц-3 ХК	1.Ц.Шинэхүү- ТӨБЗГ-ын мэргэжилтэн 2.Э.Эрдэнэхишиг-ТӨБЗГ-ын ахлах мэргэжилтэн
3	Дулааны цахилгаан станц-4 ХК	1.Д.Нарангэрэл - ТӨБЗГ-ын ахлах мэргэжилтэн 2.Д.Эрэвгийлхам- ТӨБЗГ-ын мэргэжилтэн
4	Дарханы дулааны цахилгаан станц ХК	1.В.Дарханбаатар-ТӨБЗГ-ын ахлах мэргэжилтэн 2.Т.Санчиргаав- ТӨБЗГ-ын мэргэжилтэн
5	Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ХК	1.Д.Одмаа - ТӨБЗГ-ын мэргэжилтэн 2.Б.Өнөрмаа - ТӨБЗГ-ын мэргэжилтэн
6	Налайхын дулааны станц ХК	1.М.Болор-ТӨБЗГ-ын мэргэжилтэн 2.Г.Нямдаваа - ТӨБЗГ-ын мэргэжилтэн
7	Багануурын дулааны станц ХК	1.Б.Эрдэнэбулган - ТӨБЗГ-ын мэргэжилтэн 2.Б.Сүнжидмаа - ТӨБЗГ-ын мэргэжилтэн
8	Даланзадгадын дулааны цахилгаан станц ХК	1.Л.Ишжамц - ТӨБЗГ-ын мэргэжилтэн 2.Т.Хулан - ТӨБЗГ-ын мэргэжилтэн
9	“Дулаан шарын гол” ХК	1.С.Цэрэндорж - ТӨБЗГ-ын мэргэжилтэн 2.Б.Гэрэлтуяа - ТӨБЗГ-ын мэргэжилтэн
10	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ХК	1.А.Дагвадорж - ТӨБЗГ-ын Дэд дарга 2. Л.Сэлэнгэ - ТӨБЗГ-ын ахлах мэргэжилтэн
11	Улаанбаатар дулааны сүлжээ ХК	1.Э.Эрдэнэхишиг - ТӨБЗГ-ын ахлах мэргэжилтэн 2. Э.Ганчимэг - ТӨБЗГ-ын ахлах мэргэжилтэн
12	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ХК	1.Э.Ганчимэг - ТӨБЗГ-ын ахлах мэргэжилтэн 2.Х.Нарангаав - ТӨБЗГ-ын мэргэжилтэн
13	Дарханы дулааны сүлжээ ХК	1. Б.Амарзаяа - ТӨБЗГ-ын мэргэжилтэн 2.Э.Дуламсүрэн - ТӨБЗГ-ын мэргэжилтэн
14	Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ХК	1.Н.Цэрэнсамбуу - ТӨБЗГ-ын албаны дарга 2.Ф.Батбаатар - ТӨБЗГ-ын ахлах мэргэжилтэн
15	Дорнод бүсийн эрчим хүчний систем ХК	1.Ц.Түвшинзаяа - ТӨБЗГ-ын хэлтсийн дарга 2.Л.Сэлэнгэ - ТӨБЗГ-ын ахлах мэргэжилтэн
16	Баганур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ХК	1.Н.Ган-Эрдэнэ - ТӨБЗГ-ын мэргэжилтэн 2.М.Лхагважав - ТӨБЗГ-ын мэргэжилтэн
17	Баруун бүсийн эрчим хүчний систем ХК	1.У.Батзаяа - ТӨБЗГ-ын мэргэжилтэн 2.Д.Тунгалагтуул - ТӨБЗГ-ын мэргэжилтэн
18	Алтай-Улиастайн ЭХС ХК	1.Ф.Батбаатар - ТӨБЗГ-ын ахлах мэргэжилтэн 2.М.Баярмаа - ТӨБЗГ-ын мэргэжилтэн
19	“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ХК	1.Х.Дашдаваа - ТӨБЗГ-ын мэргэжилтэн 2.Г.Дэлгэрмаа - ТӨБЗГ-ын мэргэжилтэн
20	Диспетчерийн үндэсний төв ХХК	1.Д.Нарангэрэл - ТӨБЗГ-ын ахлах мэргэжилтэн 2.Д.Дариймаа - ТӨБЗГ-ын мэргэжилтэн

21	Хөвсгөл дулааны станц ХК	1.Л.Лхамсүрэн - ТӨБЗГ-ЫН мэргэжилтэн 2.Г.Туул - ТӨБЗГ-ЫН мэргэжилтэн
22	Ховд дулааны станц ХК	1.Х.Энхчимэг - ТӨБЗГ-ЫН ахлах мэргэжилтэн 2.У.Батзаяа - ТӨБЗГ-ЫН мэргэжилтэн
23	Улаангомын дулааны хоёрдугаар станц ХК	1. Д.Наранчимэг - ТӨБЗГ-ЫН ахлах мэргэжилтэн 2. Н.Ган-Эрдэнэ - ТӨБЗГ-ЫН мэргэжилтэн